



КРИПТО ҮНДЭСТЭН ХК

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

БИДНИЙ ТУХАЙ

Компани нь 2002 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд ус суваг, засвар үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулах баримт бичигт заасан. Компани нь 2020 онд үйл ажиллагаа явуулаагүй. 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр нэр бүхий хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр Ард Бит ХХК нь компанийн 99.9 хувийн хувьцааг худалдаж авсан. Ингэснээр цаашид компанийн үйл ажиллагааг сэргээж, блокчэйн технологи болон криптовалютын салбарт үйл ажиллагаа явуулахаар болсон.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болон ээлжит бус хурлаараа компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, хувьцаа эзэмшигчдэдээ мэдээлэл хүргэх зэргээр компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх бэлтгэл ажлыг шат дараатайгаар хийж гүйцэтгэж байна.

ТОП 40 Зах зээлийн үнэлгээ

ТОП 1 Хамгийн өсөлттэй үнэт цаас

ТОП 13 Идэвхтэй арилжигдсан 30 үнэт цаас



КОМПАНИЙН ТУХАЙ



Үнэт цаас гаргагчийн нэр, улсын
бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код

Крипто Үндэстэн ХК, 410001002, MSE:CNF



Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо
ширхэг

113,212



Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр

Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК



Бизнесийн үйл ажиллагааны салбар

**Гадаад худалдаа
Крипто валют судалгаа
Бизнесийн зөвлөгөө
Технологи, хөрөнгө оруулалтын зөвлөгөө**

КРИПТО ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЙЛАН

- Зах зээл +1.99% өсөв, I улиралд уналттай байсан ч II улиралд +25% сэргэлт гарч, тогтворгүй хэдий ч боломж ихтэй орчин бүрдэв.
- Bitcoin болон олон койн шинэ дээд түвшинд (ATH) хүрч, BTC 112,000 ам.долларын ханшид хүрэв. BTC-ийн зах зээлийн үнэлгээ 2 их наяд ам.долларыг давж, крипто зах зээлийн 65.1%-ийг бүрдүүлэв.
- Спот BTC ETF-үүдэд 13.7 тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалт орж, институционал хөрөнгө оруулагчдын эрэлт хүчтэй хэвээр байна. BlackRock үүнийг тэргүүлж байна.
- Олон нийтийн 140+ компани нийт 848.1 мянган BTC хадгалж байгаа нь BTC-г албан ёсны санхүүгийн хэрэгсэл гэж үзэх хандлагыг баталж байна.
- Зохицуулалт сайжрав: АНУ-д GENIUS Act батлагдаж, Трампын засаглал криптог дэмжиж эхэлсэн бол Европын Холбоо MiCA (Крипто хөрөнгийн зах зээлийн зохицуулалт)-г хэрэгжүүлж эхэлсэн. Ази дахь бодлого бүс нутгаас хамааран ялгаатай хэвээр байна.
- Stablecoin зах зээл 250 тэрбум ам.долларыг давж, шинэ дээд үзүүлэлт тогтоов. USDC хамгийн хурдацтай өсч (~\$61.5B), \$7T+ онцгой гүйлгээ хийгдэв.
- DeFi хэрэглээ тогтвортой өсөж, DEX-ийн арилжаа зах зээлийн 29%-д хүрч, институцийн оролцоо, RWA (бодит хөрөнгөөр баталгаажсан токен) интеграц трэнд хандлага болж байна.
- Ethereum институционал хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж, Pectra шинэчлэл, спот ETH ETF-үүдийн оролт, мөн 35.4M ETH стэйктэйгээр үргэлжлүүлэн манлайлав.
- Solana, BNB Chain, Tron зэрэг L1 сүлжээнүүд хөгжлөө үргэлжлүүлж, Solana өндөр гүйлгээ, BNB Chain олон салбарт (AI, memecoin, RWA) тэлэлт хийв.
- AI ба blockchain хосолсон шинэ технологи (DeFAI, DePAI, DeSci) эрчимтэй хөгжиж, шинэ хэрэглээний тохиолдлууд бодит амьдралтай уялдах эхлэл тавигдлаа.

#САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	2024 -12-31	2025-06-30
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	469,795	22,500,493
Дансны авлага	759,188,169	254,208,378
Бусад авлага	10,498,686	
Бусад санхүүгийн хөрөнгө		201,020,000
Урьдчилж төлсөн зардал	5,386,679	92,468,321
Бусад эргэлтийн хөрөнгө	4,172,953,572	7,199,725,638
Эргэлтийн бус хөрөнгө		1,495,848
Хойшлогдсон татварын хөрөнгө	29,487,968	
Нийт хөрөнгө	4,977,984,869	7,771,418,678
Өр төлбөр ба эздийн өмч		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны болон бусад өглөг	381,813,695	624,658,554
Татварын өглөг	671,321	4,221,229
Урт хугацаат өр төлбөр		540,100,000
Хойшлогдсон татварын өр төлбөр	-2,465,509	310,838,837
Өр төлбөрийн нийт дүн	382,485,017	628,113,271
Эздийн өмч		
Хувь нийлүүлсэн хөрөнгө	11,321,200	11,321,200
Нэмж төлөгдсөн капитал	8,421,200	8,421,200
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-22,189,584	2,797,540,262
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	4,380,000,000	3,464,259,336
Хуримтлагдсан ашиг алдагдал	195,757,452	10,058,062
Эздийн өмчийн дүн	4,595,499,851	6,291,600,059
Нийт өр төлбөр ба эздийн өмч	4,977,984,869	7,771,418,678

#ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	2025-06-30
Хүүний орлого	
Бусад орлого	64,806,612
Борлуулалт, маркетингийн зардал	
Ерөнхий ба удирдлагын зардал	114,794,068
Санхүүгийн зардал	55,561,874
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	(1,044,829)
Бусад ашиг (алдагдал)	42,899
Татварын өмнөх ашиг (алдагдал)	(106,551,260)
Орлогын татварын зардал	
Татварын дараах ашиг (алдагдал)	(106,551,260)
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(106,551,260)
Бусад дэлгэрэнгүй орлого	
Орлогын нийт дүн	(106,551,260)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	

**КРИПТО ҮНДЭСТЭН ХК-ИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>	
<i>Тайлагнах хугацаа</i>	2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдөр
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>	Крипто Үндэстэн ХК, 9007001008, 410001002, MSE: CNF
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа /Гадаад худалдаа/
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	113,212 ширхэг
<i>Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	Бэлтгэсэн: Б.Тэлмүүн Хянасан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

1.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>	
	<i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>	Тайланг хавсаргав
	<i>Орлогын тайлан</i>	Тайланг хавсаргав
	<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>	Тайланг хавсаргав
	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	Тайланг хавсаргав
2.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>	
	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хурлаар хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулна.	
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашигийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>	
3.1	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	Нийт хөрөнгийн өгөөж (ROA): -1.3% Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE): -1.5%

3.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	
3.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Олон улсын криптовалютын ханшийн өсөлт бууралт нөлөөлнө.
3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Байхгүй.	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
	Байхгүй.	
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	Крипто Үндэстэн ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2025 оны хагас жилийн байдлаар нийт 4 удаа ээлжит болон эчнээ хэлбэрээр хуралдаж, холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажиллалаа. Мөн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 сарын 30-ны өдөр зохион байгуулсан байна.	
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:		Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:
Овог, нэр: Отгонбаяр Мөнх-Оргил Албан тушаал: “Крипто Үндэстэн” ХК-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг:.....  (Тамга/тэмдэг)		Овог, нэр: Б.Тэлмүүн Албан тушаал: “Крипто Үндэстэн” ХК-ийн нягтлан бодогч Гарын үсэг:  (Тамга/тэмдэг)